



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 761

Улаанбаатар хот

Хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Булган-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн нийт 82,453,921.00 (наян хоёр сая дөрвөн зуун тавин гурван мянга есөн зуун хорин нэгэн) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. "Булган-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга В.Дарханбаатар, гүйцэтгэх захирал Э.Пүрэвдэмбэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны  
өдрийн 76/ дугаар тогтоолын хавсралт

**"БУЛГАН-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн  
жагсаалт**

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	LOVOL маркийн, трактор, 33-46 БУ улсын дугаартай,	2007/2009	8990 м/цаг	28,882,384.00		500,000.00
2	Мицубуши пажеро маркийн, Суудлын автомашин, 59-49 БУЛ улсын дугаартай, арлын дугаар- JMYLNV96W9J001246	2009/2010	440000	53,571,537.00	320,000.00	3,000,000.00
				82,453,921.00	320,000.00	3,500,000.00
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>			<b>82,453,921.00</b> (наян хоёр сая дөрвөн зуун тавин гурван мянга есөн зуун хорин нэгэн)	<b>320,000.00</b> (гурван зуун хорин мянга)	<b>3,500,000.00</b> (гурван сая таван зуун мянга)